

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.БУМ-ОЧИР

**НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН 4 ДҮГЭЭР ЗҮЙЛД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуульд “-төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж” хэмээн эрхэм зорилгоо болгон тунхагласан. Мөн Соёлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт Монголын соёлын давтагдашгүй хэв шинж, уламжлалт мэдлэг, сэтгэлгээний илэрхийлэл болсон соёлын өвийг хамгаалж, баталгаажуулна хэмээн төрөөс тусгайлан дэмжлэг үзүүлэх соёлын үйл ажиллагааны чиглэлийг баталгаажуулж өгсөн.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.6-д Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн хэмээн тусгажээ.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд Биет бус соёлын өвийг хуульчлахдаа тус зүйлийн 7.1.6 дахь хэсэгт: ардын ёс заншил, зан үйл; 7.1.7 дахь хэсэгт: ардын уламжлалт мэдлэг, арга ухаан; 7.1.8 дахь хэсэгт: ардын бэлгэдэх ёсны уламжлал; хэмээн тусгасан байх ба энэ нь Монгол түмний өв соёлын хэв шинж, түүний онцлогт тохирсон уламжлал, зан үйл нь гарцаагүй хамгаалах ёстой өв мөн хэмээн үзэж буй явдал юм.

Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/759 дугаар тушаалаар баталсан Монгол Улсын биет бус соёлын өвийн төлөөллийн үндэсний бүртгэлд цагаан сар нь “Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом

наадгай, уриа дуудлага”-ын 3 дахь ай савд хамаарч “Цагаан сарын уламжлалт ёслол, зан үйл” хэмээн бүртгэгдсэн бөгөөд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050 баримт бичгийн зорилт 1.2-т “Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно” гэж заасан байдаг.

Монгол Улс Үндсэн хууль болон бусад хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг зэрэгтээ үндэсний өв соёл бол Монголын ард түмний дахин давтагдашгүй өвөрмөц онцлог хийгээд гарцаагүй хадгалан хамгаалж, өвлүүлэн уламжлуулж, хөгжүүлэн дэлгэрүүлэх учиртай үнэт өв, амин чухал дархлаа гэж үзэж байгаа энэ агуулгын хүрээнд цагаан сарын битүүний өдрийг нийтээр тэмдэглэх баярын өдөр болгон хуульчилж хамгаалах нь зүйтэй гэж үзэж байна.

1.2.Практик шаардлага

Аливаа үндэстэн ард түмэн, улс орон төрт ёс, түүх соёлоо хадгалан хамгаалж, үндэстний эв нэгдлээ бататган бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой “үндэсний баяр”-тай (national holiday) байдаг бөгөөд Цагаан сар бол Монгол үндэстний олон зууны түүхтэй нэн чухал хоёр том үндэсний баярын нэг юм. Монголын хэмээх тодотголтой Цагаан сар бол суурин соёл иргэншилтэй Азийн бусад ард түмний хаврын баяраас эрс ялгаатай, нүүдлийн соёл иргэншлийн дахин давтагдашгүй өвөрмөц онцлогтой, Хүннүгийн хаад язгууртнуудаас эхлээд Чингис хаан Их Монгол Улсаа байгуулаад ёслол тэмдэглэж байсан түүхтэй төрт ёсны их баяр ёслол билээ. Тиймээс Цагаан сар бол зөвхөн билгийн тооллын шинэ оныг тэмдэглэдэг гэр бүл, ураг төрлийн баяр биш, эсвэл зөвхөн нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн тэмдэглэж ирсэн малчдын баяр биш, харин төр түмний их баяр ёслол юм. Түүнчлэн Цагаан сар бол байгаль дэлхий, цаг улирлаа танин мэдсэн өвөг дээдсийн мэдлэг ухаан, эдийн болоод оюуны соёл, ёс заншлын олон зүйлсийн цогцолбор чуулбар, мэндлэх, хүндлэх, талархах, бэлгэдэх ёсыг ёслол гүйцэтгэдэг Монгол хүний дархлаа, даяаршлын давлагааг сөрөн тэсвэрлэх чадавхсг нэмэгдүүлж, улс үндэстэн оршин тогтнох баталгаа болж байдаг Монгол үндэстний үнэт өв юм.

Тиймээс Цагаан сарын баярыг өргөн олноороо ёслол тэмдэглэх нь нийтээрээ амрах тухай асуудлаас илүүтэй жилд ганц тохиодог Монгол Монголоороо оршин тогтнох алдаж болшгүй боломж юм. Энэ боломжоо нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага, практик ач

холбогдол бидний энэ цаг үед улам бүр нэмэгдсээр байгааг Та бид харж байгаа. Гэтэл Цагаан сарын баярын салшгүй нэгэн хэсэг болох битүүний өдөр ажлын өдөр байгаа нь Цагаан сарын ёс заншил, утга бэлгэдлийн цогцолборыг салган сарниулах, ач холбогдлыг нь бууруулах, хүрээ хэмжээг нь хязгаарлах, улмаар Монгол Монголоороо оршин тогтнох боломжийг бага боловч хумих нөхцөл болж байгаа хэрэг юм.

Түүнчлэн одоогийн дагаж мөрдөж буй Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт заасан 3 хоногийн амралтын өдөрт битүүний өдөр багтдаггүй нь битүүний өдрийн зарим ёс заншил орхигдох, Цагаан сарын баярын бэлтгэлээ хангаж амжихгүй байх, осол гэмтэл, хэрэг зөрчил гарах тохиолдол ч нэмэгддэг байна.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод улсын хүн амын 50 хувиас дээш буюу 1,7 сая орчим хүн ажиллаж амьдарч байна. Уламжлалт Цагаан сарын баярын хувьд гэр бүлээрээ цуглах, ахмад настнаа хүндлэх зэрэг ёс заншил, зан үйл, өв соёлын ихээхэн онцлогтой. Тийм ч учраас Монголын ард түмний аж төрөх онцлог, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нөхцөл байдлаас хамаараад Цагаан сарын баярын бэлтгэл хангах, орон нутагт зорчих шаардлага үүсдэг нь 3 хоногийн амралтын өдөрт амжихгүй байх, замын хөдөлгөөний түгжрэл саатал үүсэх, осол гэмтэл гарах, улмаар үүнээс шалтгаалсан бухимдал үүсэх, гэмт хэрэг зөрчил нэмэгдэх нөхцөл болдог байна.

Энэ асуудалтай холбоотойгоор жил бүрийн 1, 2 дугаар сард Цагаан сараар амрах өдрийг сунгах, амралтын өдрийг бямба, ням гарагтай давхацвал ажлын өдөрт шилжүүлэх талаар Засгийн газраас Цагаан сарын баярын амралтыг сунгах, ажлын өдрийг амралтын өдөрт шилжүүлэх тухай дараах тогтоолуудыг гаргаж байжээ. Үүнд:

2019 он: АЖЛЫН ӨДӨР ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ №49 тогтоолоор Цагаан сарын баяраар иргэдийн ажил, амралтын өдрийг зохицуулах зорилгоор 2019 оны 2 дугаар сарын 8-ны Баасан гарагийн ажлын өдрийг 2 дугаар сарын 2-ны өдрийн Бямба гарагийн амралтын өдөрт шилжүүлсэн.

2023 он: АЖЛЫН ӨДӨР ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ №43 тогтоолоор Цагаан сарын баяраар иргэд ажил, амралтаа зөв зохицуулах боломж бүрдүүлэх зорилгоор 2 дугаар сарын

24-ний баасан гарагийн ажлын өдрийг 2 дугаар сарын 18-ны бямба гарагийн амралтын өдөрт шилжүүлсэн.

2025 он: АЖИЛ, АМРАЛТЫН ЦАГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ №109 тогтоолоор Монгол үндэстний уламжлалт баяр Цагаан сарын билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1 тасарч, шинийн 2, 3-ны өдөр Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 03 дугаар сарын 03, 04, 05-ны өдрийн Даваа, Мягмар, Лхагва гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 оны ажлын жилд багтаан нөхөж ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасан.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзвэл:

- 2020 онд сар шинийн баярын амралт даваа-лхагва гарагт таарч зам тээврийн осол 323 гарсан;
- 2023 онд сар шинийн баярын амралт мягмар-пүрэв гарагт таарч зам тээврийн осол 999 гарсан;
- 2025 онд сар шинийн баяраар ЗГ-ын тогтоол гарч 7 хоног амарсан бөгөөд зам тээврийн осол 150 гарсан нь амрах хоног олон байх, өмнөх өдөр нь буюу битүүнд нь амралтын өдөр таарах тохиолдолд зам тээврийн осол гарах эрсдэл багасаж байна.

Хоёр. Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслөөр Монголын ард түмний уламжлалт баяр Цагаан сарыг тэмдэглэн өнгөрүүлэхдээ Цагаан сарын түүхэн уламжлал, өв соёл, зан заншил, бэлгэдэл зэргийг багтаасан “битүүний ёсон” буюу битүүний өдрийн зан заншлыг Цагаан сарын баярын нэгэн адил үзэж, хууль тогтоомжийн хүрээнд зохицуулалт хийж бүх нийтээр амрах өдөр болох харилцааг зохицуулна.

Монгол Улсын хувьд 10 төрлийн баярыг бүх нийтээр амрах өдөр байхаар хуульчилсан бөгөөд одоогоор нийт 16 өдрийг амралтын өдөрт тооцон тэмдэглэн өнгөрүүлж байна. Ингэхдээ тухайн баярын өдөр нь бямба, ням гараг таарсан тохиолдолд нөхөж амрах зохицуулалт байхгүй юм.

Харин Цагаан сартай төстэй хаврын баярыг тэмдэглэдэг Азийн улс орнуудын тухайд БНХАУ хамгийн их буюу 8 хоног, бусад БНСУ, Вьетнам зэрэг улс орнуудын хувьд битүүний өдөр ороод 5 хоног хүртэл үргэлжилж байна.

Тэгвэл битүүний өдөр буюу билгийн тооллын өвлийн адаг сарын сүүлийн өдөр эсвэл хаврын тэргүүн сарын шинийн нэгний өмнөх өдрийг бүх нийтээр амрах өдөр болгон хуульчилснаар манай улсын хувьд нийт 10 төрлийн баяраар 17 өдөр амардаг байхаар өөрчлөгдөнө.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаарх санал

Бүх нийтээр амрах өдрийн тоо 1 хоногоор нэмэгдсэнээр төдийлөн сөрөг үр дагавар үүсэхгүй бөгөөд эсрэгээрээ Монголын уламжлалт баярын өдрүүдэд ажлаас чөлөө авах, хот хоорондын зорчих хөдөлгөөний ачаалал хэт ихсэх зэрэг механик эрсдэлүүдээс тодорхой хэмжээгээр урьдчилан сэргийлэх боломж үүснэ.

Аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн үйл ажиллагаа, бизнесийн гэрээ хэлцэл, тогтсон банк, санхүүгийн хэвийн үйл ажиллагаанд ноцтой саад тотгор учрахгүй бөгөөд нийтэд үйлчлэх үйлчилгээ буюу хүнсний болон барааны зах, хүнсний дэлгүүр, хүргэлтийн үйлчилгээ, хүнсний үйлдвэрүүдийн үйл ажиллагааг тасалдуулахгүйгээр зохицуулалт хийх боломжтой гэж үзэж байна.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төслийг дагалдуулан Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ